



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/17.

Улаанбаатар хот

Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгчийг
сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах
удирдамж батлах тухай

ШУТИС-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.11.2 дах заалт, ШУТИС-ийн Ректорын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Эрх олгох тухай” А/77 дугаар тушаал, ШУТИС-ийн Ректорын 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Зарим тэнхимүүдийн эрхлэгчийн сонгон шалгаруулалт явуулах тухай” А/115 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн бүрэлдэхүүн Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны удирдамж”-ийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан удирдамжийг үйл ажиллагаанд баримтлан, сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулахыг “Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн тэнхимийн эрхлэгчийг сонгон шалгаруулах комисс”-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Я.ТӨГӨЛДӨР



НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛИЙН
УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУНГУУЛ
УЛААНБААТАР ХОТ
АТ 10519-С 9087067

НХС-ийн Захирлын 2026 оны
...-ий өдрийн
... дугаар тушаалын хавсралт

ШУТИС-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛИЙН ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. ШУТИС-ийн бүрэлдэхүүн Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгчийг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү удирдамжийг баримтална.
- 1.2. Тэнхимийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа хүний эрх, нэр төр, мэргэжлийн нэр хүндийг хүндэтгэх, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал үүслээр нь ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш хандах, хууль тогтоомж, шударга ёсыг дээдлэх, нууцыг хадгалах, нээлттэй ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.
- 1.3. ШУТИС-ийн Ректорын тушаалаар батлагдсан “Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн тэнхимийн эрхлэгчийг сонгон шалгаруулах комисс” нь энэхүү удирдамжийн дагуу сонгон шалгаруулалтыг явуулж, үр дүнгийн тайлан, холбогдох материалыг ШУТИС-ийн Захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.
- 1.4. Сонгон шалгаруулалтын комиссын нэг гишүүнийг нарийн бичгийн даргаар сонгон ажиллуулна.
- 1.5. Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг сонгон шалгаруулах зарыг ШУТИС-ийн албан ёсны вэб хуудас, бүрэлдэхүүн сургуулийн веб хуудас, социал сувгууд ашиглан нийтэд хүргэнэ.

Хоёр. Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшигчид тавих шаардлага

- 2.1. Дараах шалгуур, шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн нь тэнхимийн эрхлэгчийн албан тушаалын сонгон шалгаруулалтад нэр дэвших эрхтэй. Үүнд:
 - 2.1.1. Доктор (Ph.D)-с доошгүй эрдмийн зэрэгтэй;
 - 2.1.2. Тухайн тэнхимийн сургалт, судалгааны аль нэг чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн;
 - 2.1.3. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан;
 - 2.1.4. Багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дадлага, туршлагатай;
 - 2.1.5. Мэргэжлийн чиглэлээр салбартаа нэр хүндтэй, хариуцсан нэгжийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн холбоог хөгжүүлэх чадвартай;
- 2.2. Сонгон шалгаруулалтад оролцогч иргэн зөвхөн нэг тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвших эрхтэй.

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах, бүртгэх

- 3.1. Нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
 - 3.1.1. Сонгон шалгаруулалтад оролцогчийн гараар бичсэн хүсэлт;
 - 3.1.2. Төрийн албан хаагчийн анкет, зурагтай (Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 521 дугаар тогтоолоор баталсан анкет);
 - 3.1.3. Иргэний үнэмлэхийн хуулбар (E-mongolia системээс авсан лавлагаа);



НХС-ийн Захирлын 2026 оны

дүгээр сарын 13-ний өдрийн

дугаар тушаалын хавсралт

- 3.1.4. Боловсролын түвшин, эрдмийн зэрэг цэцгийг тодорхойлсон баримт бичиг (хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах)-ийн хуулбар;
- 3.1.5. Ажлын туршлагын шаардлагыг хангасан тухай нотлох баримт (нийгмийн даатгалын дэвтэр, хөдөлмөрийн дэвтэр, албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал шийдвэр г.м.)-ийн хуулбар, лавлагаа;
- 3.1.6. Бүтээлийн жагсаалт;
- 3.1.7. Тэнхимийг хөгжүүлэх мөрийн хөтөлбөр. Мөрийн хөтөлбөрийг гурван жилээр хэрэгжүүлэхээр төлөвлөн, дараах агуулгаар боловсруулсан байна. Үүнд:
 - 3.1.7.1. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө”-ний стратегийн үндсэн зорилт, чиглэлийн хүрээнд тухайн Тэнхимд хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
 - 3.1.7.2. Тэнхимийн хэрэгжүүлдэг сургалтын хөтөлбөрүүдээр суралцагчийн тоог нэмэгдүүлэх, сургалтын чанар, материаллаг баазыг дээшлүүлэх, хөтөлбөр хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх ажил, тэдгээрийн хүлээгдэж буй үр дүн;
 - 3.1.7.3. Тэнхимийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа, нийгмийн түншлэл, мэргэжлийн үйлчилгээ болон оюутны үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажил, тэдгээрийн хүлээгдэж буй үр дүн;
 - 3.1.7.4. Тухайн тэнхимийн хөгжлийг хангахад чиглэсэн өөрийн санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажил, төсөл, хөтөлбөр;

Тайлбар: Бүрдүүлсэн баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байхыг шаардахгүй бөгөөд баримт бичгийн үнэн зөвийг хүсэлт гаргасан иргэн өөрөө бүрэн хариуцна.

- 3.2. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн иргэн бүрдүүлсэн баримт бичгийг дугтуйнд хийж битүүмжлэн, ШУТИС-ийн хичээлийн II байрны 607 тоот өрөөнд (Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн захирлын туслах) өөрийн биеэр хүлээлгэн өгнө.
Хүлээн авах хугацаа: 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагаас 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 12:00 цаг хүртэл (Ажлын өдрүүдэд)
Холбоо барих утас: 77721959 (Ажлын цагаар)

- 3.3. Сонгон шалгаруулалтын комисс нэр дэвшигчдийн ирүүлсэн материалтай танилцаж, нэр дэвшигч тус бүрээр материалын бүрдэл хангасан эсэх, нэр дэвшигч нь тавигдсан шалгуур шаардлагыг хангаж байгаа эсэх, боловсруулсан мөрийн хөтөлбөр нь 3.1.7 заалтад дурдсан агуулгатай нийцэж байгаа эсэхийг нягтална.
- 3.4. Нэр дэвшигч нь заагдсан шалгуур, шаардлагыг хангаагүй, бичиг баримтын бүрдэл дутуу бол тухайн нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтаас хасах үндэслэл болно.

Дөрөв. Нэр дэвшигчийг сонгон шалгаруулах, шийдвэр гаргалт

- 4.1. Сонгон шалгаруулалтын комисс үйл ажиллагааны хуваарийн дагуу нэр дэвшигчдийн холбогдох материалтай танилцана.
- 4.2. Тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт бичиг нь тухайн ажлын байранд тавигдах шаардлага болон бусад тавигдсан нөхцлийг хангасан эсэхийг Сонгон шалгаруулалтын комисс нэг бүрчлэн шалгаж, баримтыг дутуу бүрдүүлсэн болон тавигдах шаардлага хангаагүй тохиолдолд сонгон



НХС-ийн Захирлын 2026 оны
дүгээр сарын 15-ний өдрийн
дугаар тушаалын хавсралт

- дутуу бүрдүүлсэн болон тавигдах шаардлага хангаагүй тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна (нэр дэвшигчийн эзэмшсэн дээд боловсрол нь тухайн тэнхимийн сургалт, судалгааны аль нэг чиглэлд нийцэж буй эсэхийг комисс тогтооно).
- 4.3. Материалын бүрдэл нь шаардлага хангасан нэр дэвшигч 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр мөрийн хөтөлбөрөө Сонгон шалгаруулалтын комисс болон тухайн нэр дэвшсэн тэнхимийн хамт олонд танилцуулан үнэлүүлнэ.
 - 4.4. Сонгон шалгаруулалтын комисс 50 хүртэл оноо, тэнхимийн хамт олон 50 хүртэл оноогоор нэр дэвшигчийг үнэлнэ. Үнэлгээний аргачлал, маягтыг Сонгон шалгаруулалтын комисс боловсруулна.
 - 4.5. Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийн танилцуулга хурлын бэлтгэл ажлыг захирлын туслах, тухайн тэнхимд харьяалагдах нэр дэвшээгүй зарим багш, сургалтын мастер хамтран хариуцна. Хурлын тэмдэглэлийг тухайн тэнхимийн сургалтын мастер хөтөлнө.
 - 4.6. Сонгон шалгаруулалтын комиссын дарга хурлын дэгийг тогтоон, хурлыг удирдана.
 - 4.7. Хурлын төгсгөлд нэр дэвшигчид өгөх үнэлгээг хамт олноос нууц санал хураалтаар авна.
 - 4.8. Санал өгөх тэнхимийн хамт олны нэрсийн жагсаалтыг нарийвчлан гаргаж, баталгаажуулсан саналын хуудсаар санал авна. Хуралд танхимаар оролцсон багш, ажилтан санал өгөх эрхтэй бөгөөд түр чөлөөтэй байгаа багш, ажилтны оролцох эрхийг хязгаарлахгүй.
 - 4.9. Тэнхимийн хамт олны 2 төлөөлөл болон Сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга нууц санал хураалтыг тоолж, нэр дэвшигч бүрээр гаргана.
 - 4.10. Сонгон шалгаруулалтын комиссын гишүүдийн саналыг комиссын дарга нэгтгэнэ.
 - 4.11. Сонгон шалгаруулалтын комисс нэр дэвшигч бүрээр нийт оноог нэгтгэн эрэмбэлж, тэнхимийн хамт олонд танилцуулна.
 - 4.12. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа дуусахад Сонгон шалгаруулалтын комисс нь сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны тайлан, хурлын тэмдэглэл, шалгарсан нэр дэвшигчийн холбогдох материалууд, нэр дэвшигчдийн саналын хуудаснууд болон бусад баримт бичгийг нэгтгэн 2026.04.29-ны дотор ШУТИС-ийн Захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.
 - 4.13. Сонгон шалгаруулалтад ороогүй хүний материалыг тухайн тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэхээр Захиргааны удирдлагын газарт хүргүүлэхийг хориглоно.
 - 4.14. ШУТИС-ийн Захиргааны удирдлагын газар хүргүүлсэн материалыг нэгтгэн, үр дүнг ШУТИС-ийн Ректор танилцуулснаар Ректор тэнхимийн эрхлэгчдийг томилно. Шаардлагатай тохиолдолд Сонгон шалгаруулалтын комисс, нэр дэвшигчээс нэмэлт мэдээлэл, тодруулга авна.
 - 4.15. Хэрэв сонгон шалгаруулалтад оролцохоор нэг ч иргэн материал ирүүлээгүй бол Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн Захирал тухайн тэнхимийн эрхлэгчийн албан тушаалын шаардлага хангасан нэр дэвшигчдийг Ректор санал болгоно. Ректор санал болгосон нэр дэвшигчдийн холбогдох материалтай танилцаж, ярилцлага хийсний үндсэн дээр сонгож, сонгогдсон нэр дэвшигчийг тэнхимийн эрхлэгчээр томилно.
 - 4.16. Сонгон шалгаруулалттай холбогдон гарсан гомдол, хүсэлтийг Сонгон шалгаруулалтын комиссоос холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэн, хариуг өгнө.